



**АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТӨСНӨ ГАЗАР**

**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТӨСНӨ ГАЗРЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН НЭЭЛТТЭЙ
МЭДЭЭЛЭЛД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**УЛААНБААТАР ХОТ
2025 он**

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЭЛД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025.07.04

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.

Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны эхний хагас жилийн нээлттэй мэдээллийг цахимаар байршуулсан байдалд холбогдох хууль, Ерөнхий сайдын тогтоол, Засгийн газрын журам, УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 04 дүгээр албан даалгавар, АМГТГ-ын даргын 2022 оны 04 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлж, удирдлага болон иргэдийг цаг хугацаанд нь үнэн зөв, бодит мэдээллээр хангасан байдалд дүгнэлт, зөвлөмжөөр хангах замаар, байгууллагын гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөө, хариуцлагыг сайжруулах зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

1.1 Ашигт малтмал, газрын тосны газрын нээлтэй мэдээллийг нийтлэх үйл ажиллагаанд хяналт тавьж хууль журамд заасан үндэслэл журмын дагуу иргэдийг мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, олон нийтийг нээлтэй, ил тод үнэн зөв мэдээллээр шуурхай хангаж, гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, илэрсэн асуудлын алдаа дутагдлыг арилгуулах, дүгнэлт, зөвлөмж өгөх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЦАР ХҮРЭЭ

2.1 Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ дараах хууль тогтоомж, эрх зүйн акт, холбогдох бусад баримт бичгийг эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйл;
- Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл;
- Ашигт малтмалын тухай хуулийн 10, 11, 16, 20, 22, 28, 26, 49, 50, 54, 55, 57 дугаар зүйл;
- Газрын тосны тухай хуулийн 6, 7, 9, 11, 12, 14, 17, 19, 30, 31, 34, 36 дугаар зүйл;
- Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”;
- Ерөнхий сайдын 2022 оны 03 дугаар албан даалгавар;
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн Д/04 дүгээр “Нээлттэй мэдээллийг цахим хуудсанд байршуулах тухай” албан даалгавар;
- Ашигт малтмал газрын тосны газрын даргын 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн “Нээлттэй мэдээллийг нийтэлж байх тухай” Д/04 дүгээр албан даалгавар;
- АМГТГ-ын “Хөдөлмөрийн дотоод журам”;
- Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, стандартаар тавигдах шаардлагыг хангаж, мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв байршуулсан эсэхийг үнэлж дүгнэнэ.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

3.1 Агентлагийн 2025 оны эхний хагас жилийн нээлттэй мэдээлэл нийтэлсэн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ “Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1 болон 2 дугаар хавсралтаар батлагдсан “хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг удирдлага болгож ажилласан.

3.2 Нээлттэй мэдээллийн чанар, агуулга, мэдээллийн үнэн бодит байдал, заасан хугацаанд мэдээлсэн эсэхийг үнэлгээний дүнд харгалзан үзсэн болно.

ДӨРӨВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

“Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хууль, “Шилэн дансны тухай” хууль, Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 03 дугаар албан даалгавар болон Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын хэрэгжилтийг хангуулж хуульд ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг байгууллагын цахим хуудсанд тогтмол нийтэлж, хяналт тавьж байх зорилгын хүрээнд АМГТГ-ын дарга 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдөр “Нээлттэй мэдээллийг нийтэлж байх тухай” Д/04 дүгээр албан даалгаврыг гаргасан байна.

Албан даалгаврын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ “Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1 болон 2 дугаар хавсралтаар батлагдсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу гүйцэтгэж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан ажиллав.

Агентлагийн даргын 2022 оны 4 дүгээр албан даалгаврын 1, 2 дугаар хавсралтад туссан 113 төрлийн нээлттэй мэдээллийг холбогдох газар, хэлтэс, нэгжүүдийн хариуцсан мэргэжилтнүүд байгууллагын цахим хуудсанд тогтмол хугацаанд шинэчлэн байршуулж байхыг даалгасан байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 8.4, 8.6 дахь хэсэг, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Ашигт малтмалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэг, Газрын тосны тухай хуулийн 19 дүгээр зүйл, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6, 6.1.7 дахь хэсэгт тус тус заасан мэдээллийг албан даалгаврын 1 дүгээр хавсралтаар, хуульд заасан чиг үүргийн хүрээнд үзүүлдэг, 2 дугаар хавсралтад заасан төрийн үйлчилгээний талаарх мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1, 8.5.2-т тус тус заасны дагуу, хавсралтад заасан албан хаагчид бэлтгэж, нэгжийн даргаар хянуулан байгууллагын цахим хуудсанд заасан хугацаанд тогтмол шинэчлэн нийтэлсэн байдлыг, чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, нээлттэй мэдээлэл зэрэг чиг үүргийн дагуу ангилан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

/хүснэгт-1/

Д/д	Арга хэмжээ	Үнэлгээ
Цахим хуудсанд тогтмол байршуулж байх нээлттэй мэдээлэл /хавсралт-1/		
1	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээлэл	89%
2	Хүний нөөцийн талаарх мэдээлэл	91.6
3	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл	87.3
4	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д зааснаас гадна өөрийн эрхлэх асуудлын хүрээнд байнга ил тод, нээлттэй байлгах мэдээлэл	88.5
Нийт		91.2%
Төрийн үйлчилгээний нээлттэй мэдээлэл /хавсралт-2/		
1	Кадастрын хэлтэс	100
2	Ашигт малтмалын хайгуулын хэлтэс	100
3	Уул, уурхайн хэлтэс	100
4	Газрын тосны хайгуулын хэлтэс	100
5	Газрын тосны ашиглалтын хэлтэс	100
6	Газрын тосны бүтээгдэхүүний хэлтэс	100
7	Уул уурхай, газрын тосны төв лаборатори	100
Нийт		100%

АМГТГ-ын даргын 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн Д/04 дүгээр албан даалгаврын хүрээнд, мэдээлбэл зохих 113 төрлийн нээлттэй мэдээллээс 1 дүгээр хавсралтаар буюу Цахим хуудсанд тогтмол байршуулж байх нээлттэй мэдээлэл нийт 47 байна. Үүнээс 27 мэдээлэл /100 хувь/, 1 мэдээлэл /90 хувь/, 6 мэдээлэл /70 хувь/, 5 мэдээлэл /50 хувь/, 8 мэдээлэл /Үнэлэх боломжгүй/ үнэлэгдэж нийт дундаж нь 91.2 хувьтай үнэлэгдсэн. 2 дугаар хавсралт буюу Төрийн үйлчилгээний нээлттэй мэдээлэл нийт 59 байна. Үүнээс 57 мэдээлэл /100 хувь/, 2 мэдээлэл /үнэлэх боломжгүй/, нийт дундаж 100 хувь байна. /хүснэгт-2/

/хүснэгт-2/

Д/д	Арга хэмжээ	Нээлттэй мэдээллийн тоо							Үнэлгээ
		Бүгд	100%	90%	70%	50%	0%	ҮБ	
Цахим хуудсанд тогтмол байршуулж байх нээлттэй мэдээлэл /хавсралт-1/									
1	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээлэл;	11	7	1	2	1	-	-	89%
2	Хүний нөөцийн талаарх мэдээлэл	6	5	-	-	1	-	-	91.6%
3	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл;	15	10	-	3	2	-	-	87.3%
4	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д зааснаас гадна өөрийн эрхлэх асуудлын хүрээнд байнга ил тод, нээлттэй байлгах мэдээлэл;	15	5	-	1	1	-	8	88.5%
Нийт		47	27	1	6	5	-	8	91.2%

Төрийн үйлчилгээний нээлттэй мэдээлэл /хавсралт-2/									
1	Кадастрын хэлтэс	20	18			-	-	2	100
2	Ашигт малтмалын хайгуулын хэлтэс	5	5			-	-	-	100
3	Уул, уурхайн хэлтэс	8	8			-	-	-	100
4	Газрын тосны хайгуулын хэлтэс	9	9			-	-	-	100
5	Газрын тосны ашиглалтын хэлтэс	13	13			-	-	-	100
6	Газрын тосны бүтээгдэхүүний хэлтэс	2	1			-	-	-	100
7	Уул уурхай, газрын тосны төв лаборатори	2	2			-	-	-	100
Нийт		59	57			-	-	2	100%

Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр хэрэгжилт хангалтгүй үнэлэгдсэн мэдээлэл болон хариуцах нэгж, бэлтгэх албан тушаалтныг доорх хүснэгтэд харуулав.

/хүснэгт-3/

№	Нээлттэй мэдээллийн нэр	Мэдээллийг нээлттэй байлгахыг заасан хууль, журам	Мэдээллийг хариуцах хэлтэс, нэгж, бэлтгэх ажилтны албан тушаал	Мэдээллийг шинэчлэх хугацаа	Үнэлгээ	
1	Хүний нөөцийн талаар мэдээлэл					
1.8	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль 8.2.8.	ТЗУГ, асуудал, хариуцсан мэргэжилтэн	Дотоод нууц ахлах	Байнга нээлттэй байлган тухай бүр шинэчлэх	50
2	Хүний нөөцийн талаар мэдээлэл					
2.1	Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль 8.3.2.	ТЗУГ, Захиргаа хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн	асуудал ахлах	Байнга нээлттэй байлган тухай бүр шинэчлэх	50
3	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал					
3.3	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль 8.4.3. Шилэн дансны тухай хуулийн 6.1.5.	СХОХ, Ахлах нягтлан бодогч		Тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны дотор	50
3.9	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль 8.4.9.	ХШУДАГ, нийцлийн аудит мэргэжилтэн	Санхүү, дотоод хариуцсан	Байнга нээлттэй байлган тухай бүр шинэчлэх	50
4	Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал					
4.3	Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл;	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль 8.6.4.	СХОХ, хөрөнгө, материалын бодогч	Үнэдсэн бараа нягтлан	Байнга нээлттэй байлган тухай бүр шинэчлэх	50

Хууль, журам болон агентлагийн даргын албан даалгаврын хүрээнд нийтэд ил тод мэдээлэхээр заасан ч тухайн мэдээлэлтэй холбоотой үйл ажиллагаа явуулж, холбогдох шийдвэр гараагүйгээс цахим хуудсанд дараах мэдээллийг байршуулаагүй тул үнэлгээнд оруулаагүй болно. /Үнэлэх боломжгүй-3 мэдээл

/хүснэгт-4/

№	Төрийн үйлчилгээний төрөл, мэдээллийг нээлттэй байлгахыг заасан хууль, журам	Нээлттэй байлгах мэдээлэл	Мэдээллийг бэлтгэх ажилтны албан тушаал	Мэдээллийг шинэчлэх хугацаа	Ү нэ л гэ э
1	Кадастрын хэлтэс				
1.15	Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль 8.5.1	-Шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, үйлчилгээний хөлсний хэмжээ түүний зохицуулалт, төлбөр төлөх дансны мэдээлэл -Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тухай мэдээлэл;	Тусгай зөвшөөрөл цуцлах, дуусгавар болгох, цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Байнга нээлттэй байлган тухай бүр шинэчлэх Сар бүрийн ажлын эхний өдөр	Ү Б
1.16	Тусгай зөвшөөрлийг сэргээх: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль 8.5.1	-Шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, үйлчилгээний хөлсний хэмжээ түүний зохицуулалт, төлбөр төлөх дансны мэдээлэл -Тусгай зөвшөөрлийг сэргээсэн тухай мэдээлэл;	Тусгай зөвшөөрөл цуцлах, дуусгавар болгох, цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Байнга нээлттэй байлган тухай бүр шинэчлэх Сар бүрийн ажлын эхний өдөр	Ү Б

ДҮГНЭЛТ

1. 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн Д/04 дүгээр “Нээлттэй мэдээллийг нийтэлж байх тухай” албан даалгаврын 1, 2 дугаар хавсралтад заасан 113 төрлийн нээлттэй мэдээллийг холбогдох газар, хэлтэс, нэгжүүдээс хариуцсан мэргэжилтнүүд байгууллагын цахим хуудсанд тогтмол хугацаанд шинэчлэн байршуулж байхыг даалгасан. Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулах чиг үүргийн дагуу холбогдох газар, хэлтсийн мэргэжилтнүүд дээрх мэдээллийг хуульд заасан хугацаанд шинэчлэн байршуулсан үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд **91.2** хувиар үнэлэгдэв.

2. Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр хэрэгжээгүй болон хэрэгжилт хангалтгүй үнэлэгдсэн /мэдээллийг шинэчлээгүй/, /мэдээллийг байршуулаагүй/ байна. Эдгээр мэдээллийн бэлтгэдэг албан хаагчид ажлаас чөлөөлөгдсөн, өөр албан тушаалд шилжин томилогдсон учир тухайн ажлыг хариуцан хүлээн авсан албан хаагчид мэдээллийг хянаагүй дутагдал гаргасан.

3. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр хэрэгжилт хангалтгүй буюу 70 хувиар үнэлэгдсэн 6, 50 хувиар үнэлэгдсэн 5 мэдээллийн хувьд байгууллагын цахим хуудсанд нэмж байршуулах шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ

Нөхцөл байдлыг сайжруулж, дээр дурдсан эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор дэс дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх, алдаа дутагдлыг засаж сайжруулах чиглэлээр дараах зөвлөмжүүдийг хүргүүлж байна.

1. Агентлагийн нээлттэй мэдээллийн гүйцэтгэлд анхаарч, ажиллах чиглэлд бүтцийн нэгжийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд багцлан арга хэмжээ болгон тусгаж, хагас бүтэн жилээр, газар, хэлтсийн дарга нар дүгнэж ажиллах.

2. Нээлттэй мэдээллийг бэлтгэдэг ажилтан албан хаагчид ажлаас чөлөөлөгдсөн, тэтгэвэрт гарсан, жирэмсний амралттай, өөр албан тушаалд шилжин томилогдсон, тохиолдолд тухайн ажлыг хариуцан хүлээн авсан албан хаагчид цахим хуудсанд өмнө тавигдсан мэдээлэлд дахин боловсруулалт хийж хянаж ажиллах.


3. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмжийг агентлагийн цахим хуудсанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ гэсэн дэд цэсийг нэмэлтээр үүсгэж мэдээллийг бүтэн жилээр мэдээлдэг байх.

4. Шинэчлэн баталсан Засгийн газрын тогтоолийг үндэслэн АМГТГ-ын дарга 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдөр “Нээлттэй мэдээллийг нийтэлж байх тухай” Д/04 дүгээр албан даалгаврыг шинэчлэн батлуулж ажиллах.


5. Цахим хуудасны шинэчлэлт хийгдсэнтэй холбоотойгоор холбогдох стандарт, хууль, журам, мэдээллийн бодит байдал, чанарын шаардлагад хяналт тавьж ажиллахыг ТЗУГ-т

6. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг ТЗУГ-т тус тус зөвлөмж байна.


ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

Ашигт малтмал, газрын тосны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
 Д.ОЮУНЦЭЦЭГ

ХЯНАСАН:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
 В.ҮНЭНБАТ

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын мэргэжилтэн
 Б.Тэмүүжин